



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevkhagvar@audit.gov.mn
Эрдэнэт хот 2026 он	Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: В.Жавзмаа Утас: 70350757 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.25 № 95
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.МӨНХБАЯР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 168,512.6 сая төгрөгийн төсөв батлагдсаныг 1,231.9 сая төгрөгөөр бууруулж тодотгон, 167,280.7 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 153,446.4 сая төгрөгийг зарцуулжээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын тусгай дансгүй тул холбогдох зарцуулалтыг Баян-Өндөр сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны үндсэн дансаар дамжуулж байна.

Тайлант онд Баян-Өндөр сумын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Хойд бүсийн хэмжээнд ухаалаг дэлгэц, тоног төхөөрөмж худалдан авах" төсөл, арга хэмжээг батлуулж, хэрэгжүүлсэн нь сумын чиг үүрэгт хамаарахгүй байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 4 нэр төрлийн орлогын төлөвлөгөө тасарсан хэдий ч орлогын төлөвлөгөөг 8.2 хувиар давуулан биелж, аймгийн төсөвт 109,648.5 сая төгрөг төвлөрүүлжээ.

Бусад асуудлын хэсэг

Сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 16 зорилт, 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 93.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Харин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийн биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 93.4 хувь буюу "Үр дүнтэй" гэж үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		9,938,316.39	33,925,716.36
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	7,519,771.46	27,886,955.11
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,377,980.5	1,528,811.7
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	71,091.42	0.0
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	969,473.01	4,509,949.54
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		20,389,022.37	139,622,663.12
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	20,389,022.37	139,622,663.12
8	1.2.2.02 Биет хөрөнгө		19,849,288.44	110,885,152.47
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	539,733.94	28,737,510.65
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		30,327,338.76	173,548,379.47
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,000,358.76	2,709,252.67
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		2,000,358.76	2,709,252.67
13	2.1.1.03 Өглөг		2,000,358.76	2,709,252.67
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		28,326,980.01	170,839,126.8
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		28,326,980.01	170,839,126.8
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		1,745,791.49	9,461,789.34
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		26,124,390.9	154,845,929.31
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		456,797.61	6,531,408.15
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		30,327,338.76	173,548,379.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		152,754,356.68	237,915,843.92
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		138,739,002.1	163,359,103.34
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		87,311,528.9	89,744,990.54
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		92,429,819.15	95,138,316.86
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-5,118,290.25	-5,393,326.32
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		21,813,956.27	24,310,459.88
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		29,613,516.94	49,303,652.92
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	3,572,843.26	74,556,740.58
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	2,004,967.8
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		10,442,511.31	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	143,124,534.17	161,680,957.25

12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	143,124,534.17	156,893,789.1
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,668,960.08	46,810,527.96
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,309,573.34	15,243,431.79
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	685,212.26	1,971,957.02
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,816.91	357,193.54
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	253,809.77	3,352,075.72
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	0.0	272,541.46
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	84,678.94	1,027,992.93
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	5,986.34	25,705
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,469,599.92	7,437,918.12
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	2,632,282.6	17,121,712.37
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,455,574.1	110,083,261.14
24	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	4,787,168.15
25	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,629,822.5	76,234,886.68
26	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,633,598.72	3,574,947.11
27	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-8,633,598.72	-3,574,947.11
28	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	996,223.78	72,659,939.57

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	27,308,758.53		27,308,758.53
1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	21,997.69		21,997.69
1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,330,756.23		27,330,756.23
1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	996,223.78		996,223.78
1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,326,980.01		28,326,980.01
1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	28,326,980.01		28,326,980.01
1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	69,289,152.28		69,289,152.28
1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,616,132.29		97,616,132.29
1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	139,054.94		139,054.94
1.5 Өмчид гарсан өөрчлөлт	424,000		424,000
1.7 Тайлант үеийн үр дүн	72,659,939.57		72,659,939.57
1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	170,839,126.8		170,839,126.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

№	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	149,278,038.79	174,937,286.69
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	138,739,002.1	163,358,452.27
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	87,311,528.9	89,744,990.54
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-5,118,290.25	-5,393,326.32
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	21,813,956.27	24,310,459.88
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	29,613,516.94	49,303,001.86
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,701,084.4	21,065,585.49
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	26,904,639.08	28,222,037.25
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	7,793.46	15,379.12
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,525.37	11,578,834.41
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	66,525.37	383,378.41
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	2,004,967.8
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	9,190,488.2
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,472,511.31	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	135,387,704.62	140,024,118
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	135,387,704.62	140,024,118
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,815,097.52	29,858,874.59
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,311,580.24	15,288,682.65
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	682,780.4	1,972,304.86
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,816.91	357,193.54
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	254,176.97	3,237,482.77
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	0.0	258,897.35
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	84,678.94	1,172,427.8
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	5,986.34	26,505
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,969,152.76	7,204,339.25
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	278,924.97	341,041.37
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,572,607.1	110,165,243.41
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,890,334.17	34,913,168.68
29	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	10,579,953.22	14,223,285.03
30	1.1.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,579,953.22	14,223,285.03
31	1.1.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	10,579,953.22	14,223,285.03
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,579,953.22	-14,223,285.03
33	1.1.3.1 Бусад эх үүсвэр	286,538.35	0.0
34	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000	322,700
35	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	136,538.35	-322,700

36	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,446,919.29	20,367,183.65
37	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,072,852.17	7,519,771.46
38	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,519,771.46	27,886,955.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Татаас, санхүүжилтийн орлого	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	160,451,285.7	172,867,461.9	12,416,176.2	107.7
3.1.01.1.1 Татварын орлого	150,798,157.5	163,358,452.3	12,560,294.8	108.3
3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	23,302,700.0	24,310,459.9	1,007,759.9	104.3
3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	32,861,596.9	49,303,001.9	16,441,405.0	150.0
3.1.01.1.2 Татварын бус орлого	9,653,128.2	9,509,009.6	- 144,118.6	98.5
3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	462,640.0	318,521.4	- 144,118.6	68.8
3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	-	-	-	-
3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	9,190,488.2	9,190,488.2	-	100.0
3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	167,943,328.4	153,446,438.0	14,496,890.4	91.4
3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	145,290,276.4	138,987,274.1	-6,303,002.3	95.7
3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,939,551.5	28,893,710.6	-6,045,840.9	82.7
3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,445,437.9	15,287,996.6	-2,157,441.3	87.6
3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,276,264.3	1,972,226.0	-304,038.3	86.6
3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	443,704.1	317,593.5	-126,110.6	71.6
3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	3,531,069.4	3,195,430.0	-335,639.4	90.5
3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	285,904.4	255,222.4	-30,682.1	89.3
3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	1,155,510.8	1,046,129.7	-109,381.1	90.5
3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	39,508.5	26,505.0	-13,003.5	67.1
3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,429,578.9	6,464,711.1	-2,964,867.8	68.6
3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	332,573.2	327,896.4	-4,676.8	98.6
3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,350,724.9	110,093,563.4	- 257,161.5	99.8
3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	109,810,946.2	109,810,946.2	-	100.0
3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	539,778.7	282,617.2	-257,161.5	52.4
3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,003,052.0	14,136,463.9	-7,866,588.1	64.2
3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	650,000.0	322,700.0	-327,300.0	49.6
4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,514,101.0	7,514,101.0	
5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	27,816,427.6	27,816,427.6	
6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	-	

6.2	АЖИЛЛАГСДЫН ТОО	643	643	-	
6.5	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	643	643	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,989,921.60
	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,755,860.14
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	234,061.46
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,108,618.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,108,618.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,036,938.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	686.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,052.77
2105	Нормативт зардал	3,675.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	166,173.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,771,527.51
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,145.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,680.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	71,680.00
4	Төвлөрүүлэх шилжүүлэг	881,302.73

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Төсвийн шууд болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудит

Баян-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6 байгууллага тайлангаа нэгтгүүлсэн ба үүнээс 2 байгууллагыг түүвэрт хамруулж, 4 байгууллагад санал дүгнэлт гаргажээ.

Хүснэгт №9 Санхүүгийн тайлангийн аудит санал дүгнэлтийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр (тоогоор)					Түүвэр	Нийт дүн
		Санал дүгнэлт гаргасан						
		Өөрчлөлт-гүй	Хязгаар-лалттай	Татгалз-сан	Хамраг-даагүй			
1	Төсөвт байгууллага	1	3	-	-	2	6	
2	Төсөл, сан	-	-	-	-	-	-	
	ДҮН	1	3	-	-	2	6	

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,658.5 сая төгрөгийн 35 зөрчил илэрснээс, 55.2 сая төгрөгийн 13 төлбөрийн акт тогтоож, 1,000.5 сая төгрөгийн 12 албан шаардлага хүргүүлж, 602.8 сая төгрөгийн 12 зөвлөмж өгсөн байна.

3.2 Баян-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Баян-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 168.3 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Баян-Өндөр сумын хоршоо хөгжүүлэх сангийн нийт авлага 863.8 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 168.3 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн ч авлагын тодруулгад хугацаа хэтэрсэн талаар тайлагнаагүйг авлагын насжилтыг тодорхой болгож тайлагнасан.

Аудитаар нийт 1,811.2 сая төгрөгийн зөрчил илэрч 7 зөвлөмж өгсөн.

3.3 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

3.4 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

3.5 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Татварын орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумын татварын орлогын төлөвлөгөө 8.2 хувиар давж биелсэн ч цалин, түүнтэй адилтгах орлогын албан татвар, хөрөнгийн орлого, шууд бус орлого, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн

төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын татварын орлогыг бүрдүүлэх талаар Татварын газартай хамтран ажиллаж, ажлын уялдааг сайжруулах.

2. Татварын орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд малын тоо толгойн албан татварт 63.9 сая төгрөгийн, ус, рашааны нөөц ашигласны төлбөрт 15.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн байтал 2026 оны төсөв малд ногдуулах албан татварыг 35.0 сая төгрөгөөр батлуулж, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Малд ногдуулах албан татвар болон ус, рашаан ашигласны төлбөрийн хуульд заасны дагуу төлөвлөж, төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах.

3. Татварын бус орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд спорт зал, Хот тохижуулах газрын үйл ажиллагаанаас орлого төвлөрүүлэх судалгаа тооцоог хийгээгүй, төсөвт байгууллагын өөрийн орлогыг төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын спорт заал, Хот тохижуулах газрын өөрийн үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогыг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, төсөвт тусгаж байх.

4. Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжсэн 123 ТАХ-ний хугацаа дууссан барьцаа хөрөнгийг 2026 оны шилжих үлдэгдлээр төсөвт батлуулж, өр төлбөрийг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллага, иргэн тус бүрээр барьцаа хөрөнгийн дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, эзэн холбогдогчгүй барьцаа хөрөнгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх.

5. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Баян-Өндөр сумын Засаг даргын эрхлэх хүрээний харьяа 6 байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 249.1 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 55.2 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 1,000.5 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлж, 602.8 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмж өгсөн байна. Сумын ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн хяналт үр нөлөөгүйгээс орон нутгийн нэмэгдэл 225.6 сая төгрөг илүү олгож, анхан шатны баримтын бүрдэл хангуулаагүй 8.6 сая төгрөгийн гүйлгээг баталгаажуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудын батлагдсан төсөв, зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулах.

6. Санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн тодруулгын тэмдэглэлийг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, хөтөлбөр арга хэмжээгээр төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"

гэж заасантай нийцээгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн тодруулгын тэмдэглэл, хөтөлбөр арга хэмжээгээр төсвийн гүйцэтгэлийн тайланг зохих журмын дагуу бэлтгэж байх.

7. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд ТТЗ-ийн мэдээлбэл зохих 169 мэдээллээс 3 мэдээллийн хугацаа болоогүй, 4 мэдээллийн хугацааг хоцроож, мэдээлбэл зохих дараа жилийн төсвийн төсөл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг оруулах мэдээлэл байхгүй гэж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”; 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”; Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”; 7.1-т “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Баян-Өндөр сумын Засаг дарга	1	168.3			1	168.3	1	168.3	-	-	-	-
Дүн	1	168.3	-	-	1	168.3	1	168.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая

төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баян-Өндөр сумын Засаг дарга	6	1,811.2					6	1,811.2				
Дүн	6	1,811.2					6	1,811.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Баян-Өндөр сумын Засаг дарга	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	-	-	-	-	-	1	-

7. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл – Байгууллагаар

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ	1	249.10			1	249.10	1	249.10				
Хот тохижуулах газар	1	0.03	1	0.03			1	0.03				
ДҮН	1	249.13	1	0.03	1	249.10	1	249.13				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл – Байгууллагаар

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс											
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баян-Өндөр сумын ЗДТГ	11	247.1	5	39.7	1	193.1	5	14.3						
Баян-Өндөр сумын ИТХурал	5	47.8	1	2.0	2	44.3	2	1.5						
Баян-Өндөр сумын ОНХСан	3	631.3	0	0.0	2	86.1	1	545.2						
Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан	0	0.0	0	0.0	0	0.0	2	0.0						
Хот тохижуулах газар	12	673.3	6	13.1	4	647.4	1	0.0						
Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	4	59.0	1	0.4	2	16.8	1	41.8						
Дүн	35	1,645.7	13	55.2	12	987.7	12	602.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал – Байгууллагаар

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хот тохижуулах газар	1	12.8					1	12.8
Дүн	1	12.8	0	0.0	1	12.8	0	0.0
Нийт дүн	1	12.8	0	0.0	1	12.8	0	0.0